

АКАДЕМИЧ БАДАМЫН ЛХАМСҮРЭНГИЙН 90 НАСНЫ ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

Шинжлэх Ухааны Академийн гишүүн, академич, түүхийн шинжлэх ухааны доктор Бадамын Лхамсүрэнгийн 90 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг ШУА-иас зохион байгууллаа.

Хуралд “Академич Б.Лхамсүрэн – Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, нэрт эрдэмтэн” үндсэн илтгэлийг ШУА-ийн ерөнхийлөгч, Академич Б.Энхтүвшин, “Академич Б.Лхамсүрэнгийн нийгэм улс төрийн үйл ажиллагаа” илтгэлийг Академич Ж.Болдбаатар, “Б.Лхамсүрэнгийн бүтээлд Монголын гадаад харилцаа, төрийн тусгаар тогтнолын асуудал тусгагдсан нь” илтгэлийг ШУА-ийн ОУСХ-ийн захирал, профессор Л.Хайсандай, “Академич Б.Лхамсүрэнгийн амьдрал, үйл ажиллагаа МАН-тай холбогдох нь” илтгэлийн МАН-ын даргын зөвлөх, Доктор О.Эрдэнэчимэг нар тавьж хэлэлцүүлээ.

Академич Б.Лхамсүрэн гуайн тухай дурсамжийг ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгийн захирал, Академич Б.Чадрраа, МАХН-ын нарийн бичгийн дарга асан Ц.Балхаажав, МАХН-ын дарга асан Г.Очирбат, ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын Бага чуулганы орлогч дарга, академич Т.Намжим, Академич Б.Лхамсүрэн гуайн охин Л.Удвал нарын хүмүүс ярьж, санал сэтгэгдлээ хуваалцлаа.

Академич Бадамын Лхамсүрэн 1923 оны 2 дугаар сарын 14-ны өдөр Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт төржээ.

Б.Лхамсүрэн 1931-1934 онд нийслэлийн 4-р бага сурууль, 1934-1938 ондө Үлгэр жишээ дунд суруульд суралцан төгсчээ. Улмаар багасуруулийн багшийн хоёр сарын курст суралцаад Булган аймгийн Бүрэгхангай сумын бага сургуулиас амьдралын гараагаа эхэлжээ. Хоёр жилийн дараа нийслэлийн 3,7 дугаар бага сургуульд багшилж байгаад 1942 онд шинээр нээгдсэн Монгол Улсын их сургуулийн тоо физикийн багшийн бэлтгэл ангид орж суралцан, 1947 онд тус сургуулийг улаан дипломтой төгссөн байна.

Б.Лхамсүрэн нь нам, төрийн хариуцлагатай албан тушаалуудыг хашиж байсны зэрэгцээ Монголын түүх, гадаад харилцаа, олон улс судлалын чиглэлээр судалгаа хийж ирсэн академич, БНМАУ-ын анхны Онц бөгөөд Бүрэн эрхт элчин цолтонгуудын нэг юм..

Тэрбээр Шинжлэх Ухааны Академийг зохион байгуулсан

1961 оны анхны чуулганаар батлагдсан 9 академич, 19 сурвалжлагч гишүүний нэг бөгөөд тэр цаг үеэс эдүгээ хүртэл эрдмийн их уурхай болсон эл байгууллагатай тасралтгүй холбоотой явж иржээ. Ой тэмдэглэх ажлын хүрээнд эрдмийн бүтээлийн эмхтгэлийг хоёр дэвтэр болгон хэвлүүлэхээр бэлтгэсэн юм. Эхний дэвтэрт Академич Б.Лхамсүрэнгийн ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “ХХ зууны Монгол” төслийн хүрээнд бичиж, “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” нэртэй 1995 онд хэвлүүлсэн ном, 2003 онд хэвлэгдсэн Академич Б.Лхамсүрэнгийн “Арван зургалдугаар жаран мину” дурсамжыг оруулсан болно. Хоёрдугаар дэвтэрт Академич Б.Лхамсүрэнгийн 90 насны ойд зориулан зохиож буй эл эрдэм шинжилгээний хурлын материал, түүний бичсэн зарим өгүүлэл, шүүмж, хамтран зүтгэгсдийнх нь дурсамж орох юм.

Тэрээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудалд холбогдох баримт, материалуудыг улсын түүхийн ба гадаад харилцааны төв архивуудаас сурвалжлан судалж, хураангуйг цуврал болгон хэвлүүлж, “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” хэмээх чамбай бүтээл туурвиж, ХХ зууны Монголын гадаад харилцааны сэдэв бүхий өгүүллүүдийг Монгол Улсын түүхийн 5 дугаар боть болон сэтгүүл, эмхтгэлүүдэд нийтлүүлсэн байна.

Хурлын үеэр Б.Лхамсүрэнгийн эрдэм дэлгэрүүлэхэд оруулсан жинтэй хувь нэмрийг үнэлж Монголын Эрдэм дэлгэрүүлэгчдийн дээд шагнал Соён гэгээрүүлэгч О.Намнандоржийн алтан медалиар шагнагдсаныг МЭДН-ийн тэргүүн доктор С.Хаш-Эрдэнэ гардуулж өгөв.

ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын
Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга,
доктор Ц.Энхчимэг